


Удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын  
18-ний өдрийн 11 хурлын 02 тоот тогтоолын  
хавсралт №.1



## **МОНГОЛЫН ЗАЛУУЧУУДЫН ХОЛБООНЫ БҮТЦИЙН БҮХ ШАТНЫ САЛБАР ХОЛБОО, ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЖУРАМ**

### **ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**


Энэхүү журмын зорилго нь Монголын Залуучуудын Холбооны (цаашид МЗХ гэх) салбар холбоо, зөвлөлүүдийн үйл ажиллагааг оновчтой үр дүнтэй ажиллуулахад оршино.

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1 Монголын Залуучуудын Холбооны бүтцийн бүх шатны салбар холбоо, зөвлөлийн /цаашид салбар цаашид салбар нэгж гэх/ үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2 Монголын Залуучуудын Холбооны бүтцийн бүх шатны салбар нэгж нь Монгол Улсын хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, бусад хууль тогтоомж, МЗХ-ны Үндсэн дүрэм, журмууд болон энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.
- 1.3 Салбар нэгж нь өөрийн тамга, тэмдэг, туг, банканд харилцах данс, гэрчилгээтэй байна.
- 1.4 Салбар нэгж нь өөрийн болон нэгж байгууллагын үйл ажиллагааны дүрэм, МЗХ-ны Үндсэн дүрэм, журмыг энэхүү журамтай уялдуулан боловсруулна.
- 1.5 Салбар нэгжийн үйл ажиллагааны хамрах хүрээ нь Монгол Улсын нутаг дэвсгэрт засаг захиргааны нэгжийн дагуу, гадаадад тухайн улс орон, бүс нутаг, хотуудад хэрэгжинэ.

### **ХОЁР. САЛБАР НЭГЖИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ТЭДГЭЭРИЙН ЭРХ ХЭМЖЭЭ**

- 2.1 Салбар холбооны удирдах дээд байгууллага нь Салбар Залуучуудын Холбооны чуулган /цаашид “чуулган” гэх/ мөн.
  - 2.1.1 Чуулганы хооронд ажиллах төлөөллийн байгууллага нь “Бага чуулган” /БЧ/ байна.
  - 2.1.2. Салбар холбооны хяналтын байгууллага нь Хяналтын зөвлөл /ХЗ/ байна.
  - 2.1.3. Бага чуулганы чөлөөт цагт Салбар холбоог шуурхай удирдлагаар хангах, бодлого удирдлагын төв байгууллага нь Тэргүүлэгчдийн хурал /ХТХ/ байна.
  - 2.1.4.“Салбар холбооны удирдлага” гэснийг Тэргүүн, Дэд тэргүүн, Тэргүүлэгчид, Нарийн Бичгийн Дарга, Хяналтын Зөвлөлийн дарга гэж ойлгоно.
- 2.2 Салбар зөвлөлийн удирдах дээд байгууллага нь Залуучуудын Зөвлөлийн хурал /цаашид “хурал” гэх/ мөн.
  - 2.2.1 Хурлын хооронд ажиллах төлөөллийн байгууллага нь “Тэргүүлэгчдийн хурал” /ЗТХ/ байна.



2.2.2. Салбар зөвлөлийн хяналтын байгууллага нь Хяналтын зөвлөл /ХЗ/ байна.

2.2.3. “Салбар зөвлөлийн удирдлага” гэснийг Тэргүүн, Дэд тэргүүн, Тэргүүлэгчид, Нарийн Бичгийн Дарга, Хяналтын Зөвлөлийн дарга гэж ойлгоно.

#### **Хурал, Чуулганы бүрэн эрх.**

2.2.1. Салбар нэгжийн дүрмийг МЗХ-ны Үндсэн дүрэмд нийцүүлэн батлах, Гүйцэтгэх Хороо дүрмийг ёсчлох;

2.2.2. Их Хурал, Үндэсний Залуучуудын Зөвлөл, Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх Хорооноос гаргасан шийдвэрийг Салбар нэгжийн түвшинд хэрэгжүүлэх шийдлийг тодорхойлох, үйл ажиллагааны төлөвлөгөө батлах

2.2.3. Салбар нэгжийн тэргүүнийг сонгох, чөлөөлөх

2.2.4. Салбар холбооны тэргүүлэгчдийг 17-оос доошгүй, Зөвлөлийн тэргүүлэгчдийг 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй сонгох, чөлөөлөх;

2.2.5. Салбар нэгжийн Тэргүүн, тэргүүлэгчдийн тайлан, илтгэлийг хэлэлцэх;

2.2.6. Салбар нэгжийн Хяналтын зөвлөлийн тайлан илтгэлийг хэлэлцэх;

2.2.7. Салбар нэгжийн Хяналтын зөвлөлийг 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулах.

2.2.8. Салбар холбооны чуулганы чөлөөт цагт ажиллах Салбар Холбооны Бага чуулганыг байгуулах.


2.2.9. Салбар холбооны бага чуулганд Салбар Холбооны тэргүүн, дэд, тэргүүн, тэргүүлэгч гишүүд, нарийн бичгийн дарга, тухайн нэгжийн салбарын тэргүүн, тэргүүлэгчдийн төлөөлөл чөлөөт бус гишүүнээр, тухайн орон нутгийн төрийн, төрийн бус, хувийн аж ахуй нэгж байгууллагын удирдах албан тушаалтан, залуучуудын төлөөлөл чөлөөт гишүүнээр сонгогдоно.

2.2.10. Ээлжит чуулган нь 2 жилд нэг удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус чуулганыг ТХ, ХЗ-ны саналаар тэргүүн зарлан хуралдуулж болно.

2.2.11 Ээлжит бус чуулганыг МЗХ-ны Хяналтын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн Гүйцэтгэх хороо зарлан хуралдуулж болно.

#### **Бага чуулганы бүрэн эрх**

2.3.1. Бага чуулган /цаашид БЧ гэх/ нь жилд нэгээс доошгүй удаа хуралдана. Гүйцэтгэх хороо, Салбар холбооны тэргүүн эсвэл Бага чуулганы гишүүдийн олонхын саналаар ээлжит бус бага чуулганыг хуралдуулж болно.



2.3.2. Бага чуулганы нийт гишүүдийн суудлын тоо 119 байна. Жид бүр Салбар холбооны тогтоосон квотоор, тогтсон хугацаанд Бага чуулганы гишүүний эргэлтэд хамрагдах сонгууль явагдана.

2.3.3. Бага чуулган дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.3.4. Шаардлагатай асуудлаар чуулганы чөлөөт цагт салбар холбооны бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох

2.3.5. Бага чуулганы нийт гишүүдийн олонхын саналаар салбар холбооны тэргүүнийг МЗХ-ны Ерөнхийлөгчтэй зөвшилцөн сонгож, чөлөөлж болно

### **Тэргүүний бүрэн эрх, үүрэг**

2.4.1. Салбар нэгжийн Тэргүүн /цаашид Тэргүүн гэх/ нь Салбар нэгжийн удирдагч мөн бөгөөд орон тооны байна.

2.4.2. Салбар нэгжийн Тэргүүн нь нэг удаа улиран сонгогдож болно.

2.4.3. Салбар нэгжийн Тэргүүн нь Хурал, Чуулган-д ажлаа тайлагнана.

2.4.4. Салбар нэгжийн Тэргүүн нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.4.4.а Хурал, Чуулганы хооронд Салбар нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах

2.4.4.б Хурал, Чуулган, Бага чуулган, Тэргүүлэгчдийн хурлыг тус тус даргалах

2.4.4.в Шаардлагатай тохиолдолд ээлжит бус Хурал, Чуулганыг зарлан хуралдуулах;

2.4.4.г Бага чуулганы хурлын товыг зарлан хуралдуулах, БЧ-ийн нийт гишүүдийн 1/3-ээс доошгүй гишүүдийн шаардлагаар БЧ-ийг тарааж дараагийн БЧ-ийг шинээр бүрдүүлэх;

2.4.4.д Нарийн бичгийн даргыг томилуулах, чөлөөлөх саналыг ТХ-д оруулах;

2.4.4.е Салбар нэгжийн ТХ-н хурлыг товлон зарлах, хуралдуулах;

2.4.4.ё Дотоод, гадаад харилцаанд Салбар нэгжийг бүрэн төлөөлөх;

2.4.4.з Бүтцийн байгууллагуудын удирдах бүрэлдэхүүнийг үүргээ хангалтгүй гүйцэтгэж байна гэж үзсэн тохиолдолд үндэслэл гарган, тухайн салбарын Хурал, Чуулганыг зарлан хуралдуулах саналыг ТХ, ХЗ-д оруулах;


2.4.4.и Салбар холбооны Тэргүүн-г дараах үндэслэлээр чөлөөлнө. Үүнд:

2.4.4. Чөлөөлөх хүсэлтээ өөрөө гаргасан;

2.4.4. Тэргүүний хавсарч үл болох албан тушаалд сонгогдсон, томилогдсон;

2.4.4. Эрүүл мэндийн шалтгаанаар;

Удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын  
18-ний өдрийн III хурлын 025 тоот тогтоолын  
хавсралт №.../



2.4.4. Нас барсан шалтгаанаар;

2.4.4. Гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон

#### **Тэргүүлэгчдийн бүрэн эрх, үүрэг**

2.5. Салбар нэгжийн Тэргүүлэгчдийн хурал нь Тэргүүн, дэд тэргүүн, тэргүүлэгчдээс бүрдэнэ. Хяналтын зөвлөл, Нарийн бичгийн дарга саналын эрхгүй хуралд орлох бөгөөд Хяналтын зөвлөлийн төлөөлөл оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

2.5.1. Тэргүүлэгчид нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Тэргүүнийг эзгүйд тэргүүний санал болгосон дэд тэргүүн эсхүл тэргүүлэгч гишүүн хурлыг даргална.

2.5.2. Тэргүүлэгчид нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.5.2.а. БЧ, ЗХ-аас батлан гаргасан урт, дунд хугацааны бодлого, чиглэл хөтөлбөр, үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

2.5.2.б. Бага Чуулган, Зөвлөлийн хурлын хурлын бэлтгэлийг хангах;

2.5.2.в. Тэргүүлэгчид нь бүтцийн болон дэргэдэх байгууллагуудыг нэгдмэл удирдлагаар хангах;

2.5.2.г. Салбар нэгжийн бодлого, үйл ажиллагааны ойрын чиглэлийг тодорхойлох;

2.5.2.д. Салбар нэгжийн жилийн ерөнхий төлөвлөгөөг батлах;

2.5.2.е. Салбар нэгжийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах үүднээс үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж үзсэн эсхүл чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан тэргүүлэгчдийг чөлөөлөх, үүрэг гүйцэтгэгч сонгох асуудлыг хурлаараа шийдвэрлэнэ.

#### **Хяналтын зөвлөлийн бүрэн эрх, үүрэг**


2.6. Салбар нэгжийн ХЗ нь өөрийн хяналтын сонгуульт байгууллага бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжийг удирдлага болгон МЗХ-ны Үндсэн дүрэм, МЗХ-ны Хяналтын зөвлөлийн ажиллах журмын дагуу үйл ажиллагаа явуулна.

2.6.1. Салбар нэгжийн ХЗ-ны бүрэлдэхүүнийг Салбар нэгжийн Хурал, Чуулганаас сонгох бөгөөд бүрэн эрхийн хугацаа 2 жил байна.

2.6.2. Салбар нэгжийн Хурал, Чуулганы чөлөөт цагт ХЗ-с орон тоо гарвал БЧ-ийн хурлаас, Салбар зөвлөлийн хувьд ТХ-с нөхөн томилно.

2.6.3. Салбар холбооны ХЗ нь байнгын 5, Салбар зөвлөлийн ХЗ нь байнгын 3 гишүүнтэй байх ба ХЗ-ны даргыг гишүүд нь дундаасаа нэр дэвшүүлж нууц санал хураалтаар сонгоно.

Удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын  
18-ний өдрийн 11 хурлын 22 тоот тогтоолын  
хавсралт №.1.



2.6.4. Салбар холбооны ХЗ-ны гишүүн нь хараат бус байж, хуулийг дээдлэн гагцхүү МЗХ-ны Үндсэн дүрэм, журам, Салбар нэгжийн дүрмэд захирагдана.

2.6.5. ХЗ-ны гишүүн нь бүтцийн бүх шатны байгууллагын үйл ажиллагаанд хариуцлагыг сахиулах үүрэгтэй оролцох, Салбар нэгжийн дүрэм, түүнтэй холбогдон гарсан журам, Чуулган, БЧ, ТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангахыг шаардах бүрэн эрхтэй.

2.6.6. Салбар нэгжийн ХЗ нь Салбар холбооны Чуулган, БЧ, Салбар зөвлөлийн хурал, Тэргүүлэгчдийн хуралд тайлан дүгнэлт хэлэлцүүлнэ.

2.6.7. Салбар нэгжийн ХЗ нь МЗХ-ны ХЗ-ийн дүгнэлт гаргах эрх бүхий дэд хороодын өргөтгөсөн бүрэлдэхүүнд багтана.

### **ГУРАВ. САЛБАР НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

3. МЗХ-ны төв байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах чиглэлээр

3.1. МЗХ-ны төв байгууллагын бодлого, тогтоол, шийдвэрийг байгууллага, олон нийтэд сурталчлан таниулах, хэрэгжилтийг зохион байгуулах, тэдгээрийг салбар нэгжүүддээ хэрэгжүүлэхэд удирдлагын дэмжлэг үзүүлэх, тайлагнах.

3.2. Салбар нэгж нь тухайн орон нутгийн залуучуудын асуудлаарх бодлогыг боловсруулах, залуучуудад тулгамдаж буй асуудлаар залуучуудад чиглэсэн судалгаа хийх, түүнд үндэслэн залуучуудыг дэмжих төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг зохион байгуулах.

3.3. Тухайн орон нутагт залуучууд өөрсдийн эрх ашигт нөлөөлөх аливаа асуудлаар шийдвэр гаргах үйл явцад оролцох, хэрэгжилтийг хамтран зохион байгуулах.

3.4. Залуучуудын нийтлэг хүсэл эрмэлзэл, эрх ашгийг хамгаалах, ухамсартай, эрүүл, бүтээлч, идэвхтэй, оролцоотой, ёс зүйтэй залуу хүнийг зөв төлөвшүүлэхэд чиглэсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;

3.5. Улс төр, эдийн засаг, бизнес, нийгэм, олон улс, төрийн бүхий л түвшинд шинэ залуу удирдагчдыг төрүүлэн гаргах бэлтгэх, төлөвшүүлэх;


### **ДӨРӨВ. САЛБАР ХОЛБООНЫ ӨМЧ ХӨРӨНГӨ, САНХҮҮЖИЛТ**

4. МЗХ-ны бүтцийн бүх шатны салбарын өмч хөрөнгө нь оюуны болон материаллаг өмч хөрөнгө татвар, үйл ажиллагааны орлого, дэмжигч хувь хүн, байгууллага, хамт олны хандиваас бүрдэнэ.

4.1 Дэмжигч иргэн хуулийн этгээдээс өгсөн хандив;

4.2. Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг;

4.3. Холбооны хэвлэл мэдээлэл сурталчилгааны орлого;



- 4.4. Үл хөдлөх хөрөнгийг худалдахдаа ҮЗЗ-ийн зөвшөөрөлтэйгөөр худалдана.
- 4.5. Эд хөрөнгийг худалдах буюу түрээслүүлж ашиглуулснаас олох орлого.
- 4.6. Хуулиар хориглоогүй бусад орлого.
- 4.7. МЗХ-ны бүтцийн бүх шатны Салбар нэгжийн санхүүгийн тайлан, шагнал, хандив, дэмжлэг туслалцаа түүнтэй холбоотой мэдээлэл ил тод байна.
- 4.8 МЗХ-ны Салбар нэгж нь үйл ажиллагаанд санхүүгийн аудитыг гишүүн дэмжигчийн саналаар оруулж болно.
- 4.9. Төрөөс болон төсвийн санхүүжилт төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд шилэн дансны тухай хуулийг мөрдөнө.

#### **ТАВ. БУСАД**

5. Салбар нэгжийн эрх барих дээд байгууллагын хурлын шийдвэрээр Салбар холбоог өөрчлөн байгуулах, шинэчлэх эсвэл татан буулгаж болно.

5.1. Салбар холбоог өөрчлөн байгуулах, эсвэл татан буулгасан тохиолдолд үүсэх харилцааг Монгол улсын Иргэний хууль, төрийн бус байгууллагын тухай хууль болон бусад хууль тогтоомж, МЗХ-ны Үндсэн дүрмийн дагуу шийдвэрлэнэ.

5.2. Салбар нэгжийн бүтцэд салбарыг үүсгэн байгуулахад дээд шатны байгууллагын удирдлага, эсвэл МЗХ-ны ЕНБД-ын тушаалаар байгуулна

#### **Хурлын шийдвэр хүчин төгөлдөр болгох**

5.3. Салбар нэгжийн Хурал, Чуулган, Бага Чуулган, Зөвлөлийн хурал, Тэргүүлэгчдийн хурал болон Хяналтын Зөвлөлийн хурлыг нийт гишүүдийн олонх нь хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчин төгөлдөр гэж үзнэ.

5.4. Салбар нэгжийн Чуулган, Бага Чуулган, Салбар зөвлөлийн хурал, Тэргүүлэгчдийн хурал тогтоол, Хяналтын Зөвлөлийн хурал дүгнэлт, шийдвэр, Тэргүүн тушаал гаргана.

5.5. Хурлын шийдвэрийг оролцогчдын цөөнхийн саналаар хүндэтгэж, олонхын саналаар шийдвэрлэнэ.